



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/128/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:                      П.Амаржаргал Утас: 88106992      Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт .....	17
Залруулсан алдаа .....	17
Аудитын зөвлөмж .....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ӨЛЗИЙТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ө.ХАШБИЛЭГ ТАНАА

2021.02.18 № 243

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

005 2021.A4 ТООТҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

005020956

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛӨХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ

6417143544  
БНДА0067 9007423

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>137,912,540.58</u></b>	<b><u>159,250,167.82</u></b>
33	АВЛАГА	00.00	9,950,000.00
335	Бусад авлага	00.00	9,950,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,950,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>137,912,540.58</b>	<b>149,300,167.82</b>
351	Түүхий эд материал	87,080,362.80	99,141,922.80
35110	Тусгай зориулалттай материал	87,080,362.80	98,193,462.80
35130	Эм боох материал	00.00	948,460.00
354	Хангамжийн материал	50,832,177.78	50,158,245.02
35410	Бичиг хэргийн материал	2,025,300.00	1,919,600.00
35420	Аж ахуйн материал	6,057,373.00	4,148,954.00
35440	Түлш, шатах тослох материал	1,250,000.00	750,000.00
35450	Барилгын засварын материал	1,699,500.00	2,065,000.00
35460	Хүнсний материал	00.11	00.11
35470	Бусад хангамжийн материал	39,800,004.67	41,274,690.91
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,441,967,501.71</u></b>	<b><u>1,412,769,310.64</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,441,967,501.71	1,412,769,310.64
392	Биет хөрөнгө	1,410,005,501.71	1,380,807,310.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,353,664,656.00	1,353,664,656.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-100,930,968.00	-202,016,543.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,500,000.00	28,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,821,428.40	-28,142,857.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,554,110.73	162,406,725.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,421,387.12	-100,171,818.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	168,310,676.37	232,586,587.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,815,387.87	-92,984,669.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,965,230.00	26,965,230.00
393	Биет бус хөрөнгө	31,962,000.00	31,962,000.00
39301	Программ хангамж	500,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	31,962,000.00	31,962,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,579,880,042.29</u></b>	<b><u>1,572,019,478.46</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,745,200.00</u></b>	<b><u>00.00</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,745,200.00	00.00
413	Өглөг	6,745,200.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,745,200.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,573,134,842.29</u></b>	<b><u>1,572,019,478.46</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,573,134,842.29	1,572,019,478.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	821,578,958.90	821,578,958.90
51101	Өмч: - төрийн	821,578,958.90	821,578,958.90
512	Хуримтлагдсан үр дүн	-111,884,920.73	-113,000,284.56
51210	Өмнөх үеийн үр дүн	-111,884,920.73	-111,884,920.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,115,363.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	863,440,804.12	863,440,804.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,579,880,042.29</u></b>	<b><u>1,572,019,478.46</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,039,007,061.24</b>	<b>1,211,873,438.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>54,463,461.24</b>	<b>109,848,388.43</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>54,463,461.24</b>	<b>109,848,388.43</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,463,461.24	109,848,388.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	415,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54,463,461.24	109,432,888.43
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>155,870,900.00</b>	<b>227,546,750.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	828,672,700.00	874,478,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,237,300.00</b>	<b>7,235,850.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,237,300.00	4,156,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,079,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>152,633,600.00</b>	<b>220,310,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,633,600.00	220,310,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,075,326,342.23</b>	<b>1,212,988,802.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,075,326,342.23</b>	<b>1,212,988,802.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,043,587,666.23</b>	<b>1,151,829,945.43</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	577,043,912.00	638,288,769.00
210101	Үндсэн цалин	577,043,912.00	638,288,769.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,605,642.00	80,412,714.50
210201	Тэтгэврийн даатгал	52,575,104.00	55,108,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,777,000.00	6,342,490.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,764,193.00	5,001,145.50
210204	Ажилгүйдлийн даатгал	934,945.00	1,080,079.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,554,400.00	12,880,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,090,460.00	204,781,318.67
210301	Гэрэл, цахилгаан	3,825,400.00	7,281,211.67
210302	Түлш, халаалт	143,583,960.00	197,346,907.00
210303	Цэвэр, бохир ус	681,100.00	153,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,566,741.00	20,350,475.67
210401	Бичиг хэрэг	1,978,200.00	966,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,532,500.00	5,324,253.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915,941.00	342,428.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	104,000.00	543,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,619,600.00	4,214,900.00
210408	Бараа материал акталсны зардал	416,500.00	8,958,994.67
2105	Нормативд зардал	84,992,623.01	42,958,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	782,695.00	1,667,740.00
210502	Хоол, хүнс	84,165,028.01	40,746,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	44,900.00	543,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,167,000.00	1,827,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	265,500.00
210604	Урсгал засвар	6,167,000.00	1,562,400.00
2107	Томилолт, зочны зардал	898,000.00	1,429,500.00
210702	Дотоод албан томилолт	898,000.00	1,429,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	852,850.00	8,777,350.00

**Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	221,850.00	8,327,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	631,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>142,370,438.22</b>	<b>153,003,817.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,438,000.00	4,322,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,611,000.00	5,354,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	128,321,438.22	143,326,717.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,738,676.00</b>	<b>61,158,856.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,882,700.00</b>	<b>14,558,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,310,400.00	13,046,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,335,000.00	1,512,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>38,340.00</b>	<b>9,126,881.33</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,340.00	9,126,881.33
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,817,636.00</b>	<b>37,473,575.50</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,817,636.00	37,473,575.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-36,319,280.99</b>	<b>-1,115,363.83</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>12,513,178.89</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,513,178.89	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-12,513,178.89</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-48,832,459.88</b>	<b>-1,115,363.83</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>984,543,600.00</b>	<b>1,102,440,550.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>415,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>415,500.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	415,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	415,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>984,543,600.00</b>	<b>1,102,025,050.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	828,672,700.00	874,478,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,237,300.00</b>	<b>7,235,850.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,237,300.00	4,156,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,079,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>152,633,600.00</b>	<b>220,310,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,633,600.00	220,310,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>984,543,600.00</b>	<b>1,091,477,850.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>984,543,600.00</b>	<b>1,091,477,850.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>952,904,924.00</b>	<b>1,030,318,993.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>577,043,912.00</b>	<b>638,288,769.00</b>

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	452,235,812.00	467,284,369.00
210102	Нэмэгдэл	80,841,600.00	107,632,100.00
210104	Урамшуулал	43,966,500.00	63,372,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,605,642.00</b>	<b>80,412,714.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,575,104.00	55,108,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,777,000.00	6,342,490.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,764,193.00	5,001,145.50
210204	Ажилгүйдлийн даатгал	934,945.00	1,080,079.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,554,400.00	12,880,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>142,595,260.00</b>	<b>211,026,518.67</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,825,400.00	7,281,211.67
210302	Түлш, халаалт	138,088,760.00	203,592,107.00
210303	Цэвэр, бохир ус	681,100.00	153,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,638,841.00</b>	<b>14,655,681.00</b>
210401	Бичиг хэрэг	2,091,200.00	1,004,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,532,500.00	5,324,253.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	915,941.00	342,428.00
210404	Ном, хэвлэл	3,202,600.00	2,796,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	104,000.00	543,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,792,600.00	4,644,900.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>87,094,419.00</b>	<b>45,941,560.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	751,445.00	2,616,200.00
210502	Хоол, хүнс	84,460,074.00	40,746,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,882,900.00	2,578,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>38,192,000.00</b>	<b>6,477,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,549,600.00
210602	Тавилга	24,192,000.00	00.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	1,927,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>898,000.00</b>	<b>1,429,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	898,000.00	1,429,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>852,850.00</b>	<b>8,777,350.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	452,850.00	8,327,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,984,000.00</b>	<b>23,309,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	4,065,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,984,000.00	19,243,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,638,676.00</b>	<b>61,158,856.83</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,782,700.00</b>	<b>14,558,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,310,400.00	13,046,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,235,000.00	1,512,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>38,340.00</b>	<b>9,126,881.33</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,340.00	9,126,881.33

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,817,636.00	37,473,575.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,817,636.00	37,473,575.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	10,962,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,962,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,962,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,962,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,962,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-10,962,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-111,884,920.73	00.00	1,573,134,842.29
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-111,884,920.73	00.00	1,573,134,842.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-111,884,920.73	00.00	1,573,134,842.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,115,363.83	00.00	-1,115,363.83
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	821,578,958.90	863,440,804.12	-113,000,284.56	00.00	1,572,019,478.46

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,095,289,200.00	1,048,604,243.17	95.74
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,095,289,200.00	1,048,604,243.17	95.74
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,075,912,700.00	1,034,045,843.17	96.11
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	647,514,500.00	638,288,769.00	98.58
210101	Үндсэн цалин	476,510,100.00	467,284,369.00	98.06
210102	Нэмэгдэл	107,632,100.00	107,632,100.00	100.00
210104	Урамшуулал	63,372,300.00	63,372,300.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	80,939,300.00	80,412,714.50	99.35
210201	Тэтгэврийн даатгал	55,108,600.00	55,108,600.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,475,200.00	6,342,490.00	97.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,180,100.00	5,001,145.50	96.55
210204	Ажилгүйдлийн даатгал	1,295,000.00	1,080,079.00	83.40
210205	Эрүүл мэндийн даатгал	12,880,400.00	12,880,400.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	217,852,000.00	211,026,518.67	96.87
210301	Гэрэл, цахилгаан	7,825,600.00	7,281,211.67	93.04
210302	Түлш, халаалт	209,344,800.00	203,592,107.00	97.25
210303	Цэвэр, бохир ус	681,600.00	153,200.00	22.48
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,873,700.00	14,655,681.00	98.53
210401	Бичиг хэрэг	1,008,200.00	1,004,000.00	99.58
210402	Тээвэр, шатахуун	5,332,500.00	5,324,253.00	99.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,000.00	342,428.00	79.08
210404	Ном, хэвлэл	2,796,900.00	2,796,900.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	603,200.00	543,200.00	90.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,699,900.00	4,644,900.00	98.83
2105	<b>Нормативд зардал</b>	64,114,600.00	45,941,560.00	71.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,616,200.00	2,616,200.00	100.00
210502	Хоол, хүнс	48,920,000.00	40,746,960.00	83.29
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,578,400.00	2,578,400.00	20.50
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,700,500.00	12,520,400.00	66.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,550,000.00	7,549,500.00	99.99
210604	Урсгал засвар	11,150,500.00	4,970,900.00	44.58
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,429,500.00	1,429,500.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,429,500.00	1,429,500.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,544,000.00	1,541,500.00	99.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,094,000.00	1,091,500.00	99.77
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	289,446,000.00	282,292,000.00	97.53

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,985,700.00	99.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,944,600.00	23,243,500.00	97.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19376500.00</b>	<b>14558400.00</b>	<b>75.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,376,500.00</b>	<b>14,558,400.00</b>	<b>75.13</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,851,500.00	13,046,400.00	73.08
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,525,000.00	1,512,000.00	99.15
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,095,289,200.00</b>	<b>1,048,604,243.17</b>	<b>95.74</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>874,478,300.00</b>	<b>837,004,724.50</b>	<b>95.71</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	874,478,300.00	837,004,724.50	95.71
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>220,310,900.00</b>	<b>211,184,018.67</b>	<b>95.86</b>
132001	Орон нутгийн төсвөөс	220,310,900.00	211,184,018.67	95.86
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>500,000.00</b>	<b>415,500.00</b>	<b>83.10</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	415,500.00	83.10
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>54.00</b>	<b>54.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	100.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>534.00</b>	<b>534.00</b>	<b>100.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>534.00</b>	<b>534.00</b>	<b>100.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	534.00	534.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>54.00</b>	<b>54.00</b>	<b>100.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	40.00	40.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,237,300.00</b>	<b>7,235,850.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>4,156,150.00</b>
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3237300.00	3079700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3237300.00	3,079,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>4156150.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>4,156,150.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	4,156,150.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,237,300.00</b>	<b>7,235,850.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,237,300.00</b>	<b>7,235,850.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,237,300.00	7,235,850.00
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ө.Хашбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 04-өөс 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш нарын мэргэжлийн чадвар, мэргэжил арга зүй, хичээл төлөвлөлтийг сайжруулснаар сурлагын чанарыг 10 -аас дээш хувиар ахиулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 742045.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15440.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1212988.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 24259.8 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1572019.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 7860.5 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	137,912.50	159,250.10	21,337.60
Мөнгөн хөрөнгө	0	0	0.00
Авлага	0	9,950.00	9,950.00
Урьдчилгаа	0	0	0.00
Бараа материал	137,912.50	149,300.10	11,387.60
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,441,967.50	1,412,769.30	-29,198.20
Үндсэн хөрөнгө	1,722,456.60	1,836,385.10	113,928.50
Хуримтлагдсан элэгдэл	-128,321.40	-143,326.70	-15,005.30
Нийт хөрөнгө	1,579,880.00	1,572,019.40	-7,860.60
Өр төлбөр	6745.2	0	-6,745.20
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,573,134.80	1,572,019.40	-1,115.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,579,880.20	1,572,019.40	-7,860.80

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд дансны авлагагүй байсан ба харин тайлант онд тайлант хугацааны эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар “Санко Маркетинг Монголиа” ХХК-аас “Ухаалаг самбар” худалдан авахаар мөнгийг шилжүүлсэнтэй холбоотой 9950.0 мянга төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 149300.1 мянган төгрөг болж 11387.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансанд 4509.0 мянган төгрөгийн дадлага хичээлийн хэрэглэгдэхүүн дээд газрын шилжүүлгээр үнэ төлбөргүй ирж, төсвийн хөрөнгөөр 6604,1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, эм боох материалын дансанд Covid-19 цар тахалтай холбоотой 2616.2 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч нөөцөлсөнтэй холбоотойгоор өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1836385.1 мянган төгрөг болж 113928.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10962.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 102305.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 108 дугаар тогтоолоор 200.0 мянган төгрөгийн ашиглалтгүй программ хангамж акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 93144.4 мянга, НҮБ-ын хүүхдийн сангаас 6435.0 мянга, тайлант оны төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 10962.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1572019.4 мянган төгрөг болж 1115.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 1115.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1211873.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 172866.3 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын дээд газрын хөрөнгө оруулалтаар 109432.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор өмнөх оноос нэмэгдсэн, тусламж санхүүжилтийн орлого 71675.8 мянган төгрөг нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 45805.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 67677.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан орлого 3998.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 1212988.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 137662.4 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 61244.8 мянган төгрөг, НДШ 8807.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 7924.5 нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1381573.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1381573.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 189811.0 мянган төгрөгөөр бууруулж 1194762.9 мянган төгрөгөөр анхны төсөв батлагдаж ирсэн. Харин анх батлагдсан ,,, төгрөгийн төсвөөс ,,,, 2020.05.06 өөрчлөлт орж 1122523.9 мянган төгрөг болж өөрчлөгдсөн, мөн оны 10 дугаар сард дахин өөрчлөлт орж 1092490.7 мянган төгрөг болсон ба 2020.12.31-ны байдлаар 1095289.2 мянган төгрөг болж төсөв баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээр санхүүжүүлэхээр 1095289.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 1094789.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр 500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 874478.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 220310.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 415.5 мянга, нийт 1094789.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1048604.2 мянган төгрөгийг зарцуулж 46684.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1048604.2 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 9225.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 526.5 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 6825.4 мянга, хангамж бараа материалын зардлыг 218.0 мянга, нормативд зардлыг 18173.0, эд хогшил, урсгал засварын зардлыг 6180.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 715.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71802 хөтөлбөрийн 80109 арга хэмжээ 9126.8 мянга, 80802 арга хэмжээ 13.0 мянга, 81801 арга хэмжээ 4805.1 мянга, 81806 арга хэмжээ 18173.0 мянга, 81834 арга хэмжээ 14659.7 мянга, 81835 арга хэмжээ 68.2, мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр арга хэмжээгээр/

мянган.төг

№	Үзүүдэл	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>НИЙТ</b>	<b>1,095,289.20</b>	<b>1,048,604.24</b>	<b>46,684.96</b>	
1	Хөтөлбөр 71802 Ерөнхий боловсрол	1,084,477.50	1,037,792.54	46,684.96	95.7
2	Арга хэмжээ 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	220,189.00	211,184.02	9,004.98	95.9
3	210301 Гэрэл, цахилгаан	7,825.60	7,281.21	544.39	93.0
4	210302 Түлш, халаалт	209,344.80	203,592.11	5,752.69	97.3
5	210303 Цэвэр, бохир ус	681.60	153.20	528.40	22.5
6	210604 Урсгал засвар	2,337.00	157.50	2,179.50	6.7
8	Арга хэмжээ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,525.00	1,512.00	13.00	99.1
9	213209 Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	1,525.00	1,512.00	13.00	99.1
11	Арга хэмжээ 81801 үдийн цай хөтөлбөр	17,851.50	13,046.40	4,805.10	73.1
12	213205 Төрөөс иргэдэд олгох тэт, урам	17,851.50	13,046.40	4,805.10	73.1
14	Арга хэмжээ 81806 Дотуур байрны үйлчилгээ	162,497.20	144,324.16	18,173.04	88.8
15	210101 Үндсэн цалин	76,768.30	76,768.30	0.00	100.0
16	210102 Нэмэгдэл	1,736.30	1,736.30	0.00	100.0
17	210104 Урамшуулал	9,164.00	9,164.00	0.00	100.0
18	210201 Нийгмийн даатгалын шимтгэл	7,521.80	7,521.80	0.00	100.0
19	210202 Тэтгэмжийн даатгал	876.70	876.70	0.00	100.0
20	210203 ҮОМШ-ний даатгал	701.40	701.40	0.00	100.0
21	210204 Ажилгүйдлийн даатгал	175.30	175.30	0.00	100.0
22	210205 Эрүүл мэндийн даатгал	1,683.40	1,683.40	0.00	100.0
23	210406 Бага үнэтэй, түргэн элэгдэх, зүйлс	1,386.00	1,386.00	0.00	100.0
24	210501 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	445.50	445.50	0.00	100.0
25	210502 Хоол, хүнс	48,920.00	40,746.96	8,173.04	83.3
26	210503 Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,336.50	1,336.50	10,000.00	11.8
27	210604 Урсгал засвар	1,782.00	1,782.00	0.00	100.0
29	Арга хэмжээ 81834 Боловсролын стандарт, сургалтыг хэвийн явуулах үйлчилгээ	499,399.80	484,779.21	14,620.59	97.1
30	210101 Үндсэн цалин	290,022.90	280,797.17	9,225.73	96.8
31	210102 Нэмэгдэл	89,818.10	89,818.10	0.00	100.0
32	210104 Урамшуулал	22,327.90	22,327.90	0.00	100.0
33	210201 Нийгмийн даатгалын шимтгэл	34,184.40	34,184.40	0.00	100.0
34	210202 Тэтгэмжийн даатгал	4,021.70	3,888.99	132.71	96.7
35	210203 ҮОМШ-ний даатгал	3,217.30	3,038.35	178.95	94.4
36	210204 Ажилгүйдлийн даатгал	804.30	589.38	214.92	73.3
37	210205 Эрүүл мэндийн даатгал	8,043.40	8,043.40	0.00	100.0
38	210401 Бичиг хэрэг	1,008.20	1,004.00	4.20	99.6
39	210403 Шуудан, холбоо, интернэт	433.00	342.43	90.57	79.1
40	210404 Ном, хэвлэл	2,796.90	2,796.90	0.00	100.0
41	210406 Бага үнэтэй, түргэн элэгдэх,	3,013.90	2,958.90	55.00	98.2
42	210501 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,170.70	2,170.70	0.00	100.0

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
43	210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,241.90	1,241.90	0.00	100.0
44	210601	Багаж, техник, хэрэгсэл	7,550.00	7,549.50	0.50	100.0
45	210604	Урсгал засвар	7,031.50	3,031.40	4,000.10	43.1
46	210702	Дотоод албан томилолт	1,429.50	1,429.50	0.00	100.0
47	210801	Бусад нийтлэг АҮТХураамж	1,094.00	1,091.50	2.50	99.8
48	210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	450.00	450.00	0.00	100.0
49	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000.00	4,985.70	14.30	99.7
50	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	13,740.20	13,039.10	701.10	94.9
52	<b>Арга хэмжээ 81835</b>	<b>Сургалтын хэвийн үйл ажиллагаа</b>	<b>183,015.00</b>	<b>182,946.75</b>	<b>68.25</b>	<b>100.0</b>
53	210101	Үндсэн цалин	100,290.20	100,290.20	0.00	100.0
54	210102	Нэмэгдэл	16,077.70	16,077.70	0.00	100.0
55	210104	Урамшуулал	31,880.40	31,880.40	0.00	100.0
56	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	12,601.00	12,601.00	0.00	100.0
57	210202	Тэтгэмжийн даатгал	1,482.50	1,482.50	0.00	100.0
58	210203	ҮОМШ-ний даатгал	1,186.00	1,186.00	0.00	100.0
59	210204	Ажилгүйдлийн даатгал	296.50	296.50	0.00	100.0
60	210205	Эрүүл мэндийн даатгал	2,965.00	2,965.00	0.00	100.0
61	210402	Тээвэр, шатахуун	5,332.50	5,324.25	8.25	99.8
62	210405	Хог хаягдал зайлуулах, хортон	603.20	543.20	60.00	90.1
63	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	300.00	300.00	0.00	100.0
64	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	10,000.00	10,000.00	0.00	100.0
65	<b>Хөтөлбөр 71806</b>	<b>Насан туршын болон албан бус боловсрол</b>	<b>10,811.70</b>	<b>10,811.70</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
66	<b>Арга хэмжээ 80101</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>10,811.70</b>	<b>10,811.70</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
67	210101	Үндсэн цалин	9,428.70	9,428.70	0.00	100.0
68	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	801.40	801.40	0.00	100.0
69	210202	Тэтгэмжийн даатгал	94.30	94.30	0.00	100.0
70	210203	ҮОМШ-ний даатгал	75.40	75.40	0.00	100.0
71	210204	Ажилгүйдлийн даатгал	18.90	18.90	0.00	100.0
72	210205	Эрүүл мэндийн даатгал	188.60	188.60	0.00	100.0
73	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	204.40	204.40	0.00	100.0

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас ажилчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 4156.1 мянган төгрөг, төлбөртэй сурах бичиг түрээсийн төлбөр 3079.7 мянга, нийт 7235,8 мянган төгрөгийн орлого орсныг бүртгэл тайланд бүрэн тусгаж 5 жилийн тэтгэмжийг холбогдох ажилтанд олгож харин түрээсийн номын орлогыг БСУГ-ын төрийн сан банкны 1009000015403 тоот дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухай бүр оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 2230864 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	5	36	35	1	
5	Тухай бүр	8	96	94	2	
	Нийт	29	151	146	3	2

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 775.9 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулах 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	775.9	1	775.9			
Нийт дүн	1	775.9	1	775.9			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15138.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

#### **Залруулсан алдаа зөрчил**

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа зөрчил байхгүй болно.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 15138.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Балансын данстай холбоотой асуудал

**1.1. Илрүүлэлт:** "Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй тул авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: "Санко Маркетинг Монголиа" ХХК хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашиггүй зарцуулахгүй байх, цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн холбогдох хууль журам, стандартыг дагаж мөрдөн үнэн зөв хөтөлж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **2. Зардлын данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Гялгар хайрхан ХХК-аас 280.0 мянга, Би Ай Эм Би ХХК-аас 908.1 мянган төгрөгийн худалдан авалтыг багаж техник хэрэгслийн зардлаас гаргасан, "Төгс Эрхэт нараадай" ХХК-аас 4000.0 сая төгрөгөөр 2 ширхэг зөөврийн компьютерыг худалдан авалтыг хичээлийн үйлдвэрлэлийн зардлаас гаргаж нийт 5188.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Багаж техник хэрэгсэл" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл: Батлагдсан төсвийн зориулалт бусаар зардлын бүлэгт хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх.


2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид батлагдсан зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй, төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж хичээл практикийн зардлыг зориулалтын дагуу ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:			
АУДИТОР		ПАМАРЖАРГАЛ	2021.02.18
Анхан шатанд хянасан:			
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН			
МЕНЕЖЕР		А.ЦЭЭНЯМ	2021.02.18
Хоёр дахь шатанд хянасан:			
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ			
АУДИТОР		Б.МӨНХБАТ	2021.02.18

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:..		
2020			БНА-2021/128/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	"Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй.	9950.0	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ө.Хашбилэг, Б.Мөнхтогтох
2	Гялгар хайрхан ХХК-аас 280.0 мянга, Би Ай Эм Би ХХК-аас 908.1 мянган төгрөгийн худалдан авалтыг багаж техник хэрэгслийн зардлаас гаргасан, "Төгс Эрхэт нараадай" ХХК-аас 4000.0 сая төгрөгөөр 2 ширхэг зөөврийн компьютерыг худалдан авалтыг хичээлийн үйлдвэрлэлийн зардлаас гаргаж нийт 5188.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	5188.1	Зөвлөмж өгөх	Захирал, нягтлан бодогч	Ө.Хашбилэг, Б.Мөнхтогтох
<b>ДҮН</b>		<b>15138.1</b>			

оОо